

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨМӨР ЗАМ ДАХЬ ЦАГДААГИЙН  
ХЭЛТСИЙН 2016 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН**

2016.04.05

Улаанбаатар хот

Нэг: Дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн

**1. Удирдах ажилтны манлайллыг дээшлүүлж, алба хаагчид ажлын  
байрны зорилго, зорилтыг хангаж ажиллах гэсэн нэгдүгээр  
зорилтын хүрээнд:**

Цагдаагийн хэлтсийн удирдлагаас 2016 онд цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд ахлахаас дээш удирдах ажилтны ажлын хариуцлага, хүнтэй ажиллах ур чадвар, өөрийгөө хөгжүүлэх, манлайллыг өндөрсгөх, цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт, хууль, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, ажлын байрны шалгуур үзүүлэлтийг ханган ажиллахад гол зорилтоо дэвшүүлсэн.

Хэлтэс нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг ханган ажиллахдаа өмнөх оны ажлын тайлан, тоон үзүүлэлтэндээ дүн шинжилгээ хийж, байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн ээлжит 1 дүгээр хуралдаанаар гэмт хэргийн зөрчлийн мэдээ тайлан, байгууллагын хяналт, шинжилгээ, хэрэглэгчийн үнэлгээний тайлангийн талаар хэлэлцэн, 2015 оны ололт, амжилт, алдаа дутагдлаа цэгнэн цаашид хийх ажлаа төлөвлөсөн.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлагаас удаа дараа ирж байгаа үүрэг ажлын чиглэлд алба хаагчийн харилцаа хандлага, сахилга хариуцлага өнөөгийн тавигдаж байгаа шаардлагад хүрэхгүй байгаа талаар дурдан үүнд удирдлагаас тавих хяналт сул ажлын шалгуур үзүүлэлтэнд сахилга ёс зүйг оруулан дүгнэхгүй байгаа талаар дутагдалтай хандсан байдаг. Энэ дагуу удирдлагаас алба хаагч нарын ажлыг дүгнэж байгаа ЦБҮАЖын код 111 –ийн хүрээнд гарсан ажлын мэдээнд сахилга ёс зүйн талаар ажлын үзүүлэлт нэмж оруулан, алба хаагчийг дэвшүүлэх, албан тушаалын цол олгуулах, дээд газрын шагналд тодорхойлохдоо гол шалгуураа болгож ирлээ.

Тус хэлтсийн хэмжээнд оршин байгаа ажлын дутагдал, цаашид анхаарах асуудлыг дан дээд байгууллагаас явуулж байгаа төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар тогтоолгон түүний мөрөөр ажлаа сайжруулахаас илүүтэйгээр дотоодын хяналт шалгалтаар илрүүлэхэд анхааран хэлтсийн даргын тушаалаар шалгалтын комиссыг томилон Дорноговь аймгийн Зам-үүд, Сайншанд зангилаадад иж бүрэн шалгалт явуулан дүнг зөвлөлийн хурлаар оруулах гэж байна.

Тус цагдаагийн хэлтсээс Цагдаагийн ерөнхий газраас 2016 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус цагдаагийн хэлтэст хэрэгжүүлэх 26-н ажил, өөрийн байгууллагын ажлын онцлогтой уялдуулан 42-н ажил, цагдаагийн байгууллагын стратегийн зорилтын хүрээнд 6 бүлэг, 68 заалттай ажлыг төлөвлөж ЦЕГ-ын дэд даргаар батлуулан биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.

Тус цагдаагийн хэлтсийн түүхт 65 жилийн ой энэ оны 8 дугаар сард тохиож байгаатай холбогдуулан түүхт ойгоо өндөр бүтээлийн, ажиллах нөхцөл бололцоо, алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдсэн, байгууллагын соёлыг түгээсэн, албаны үнэт зүйлсээ эрхэмлэн ажиллах уриан дор 23 ажлыг төлөвлөн тасгуудад хуваарилан хэрэгжилтэнд хяналт тавьж ирлээ.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингисийн удирдах ажилтны зөвлөгөөн дээр хэлсэн үг өгсөн үүрэг, сахилга хариуцлага удирдлагын манлайллыг сайжруулах, талаар тэргүүн дэд болон дэд дарга нараас өгсөн үүрэг ажлын чиглэл, тасгуудын үндсэн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн даалгавар, төлөвлөгөөний хүрээнд салбар 29 заалт бүхий төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар цагдаагийн байгууллагын хэмжээний удирдах ажилтны манлайлал, ур чадварын түвшинг үнэлэх, аттестатчилах удирдах ажилтанд тавигдах шаардлагад хүрч буй эсэхийг тогтоох шалгалтанд тус хэлтсийн удирдах албан тушаалтнууд бүрэн хамрагдан хангалттай үнэлэгдсэн.

Цагдаагийн ерөнхий газраас шинэчлэн гаргаж ирүүлсэн ажлын байрны тодорхойлолтыг алба хаагч нарт мэдээллийн цагаар Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа С.Баярбат орж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 106 ажлын байрны тодорхойлолт боловсруулах, Төрийн албаны салбар зөвлөлийн 134 дүгээр тогтоол үр дүнгийн гэрээ байгуулах аргачлалын талаар сургалт орж нийт алба хаагч нарт ажлын байрны зорилго, зорилтын үндсэн хүрээнд ажлаа төлөвлөн сар улирал, хагас, бүтэн жилээр дүгнүүлж ажиллах талаар чиглэл өгсөн.

**Байгууллагын соёл, алба хаагчдын сахилга, ёс зүй, албаны бэлэн байдлыг сайжруулах гэсэн хоёрдугаар зорилтын хүрээнд:**

Тус цагдаагийн хэлтсээс 2015 онд сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчдын зөрчлийн байдалд үнэлэлт өгч, тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодохгүй, албан үүрэг гүйцэтгэсний төлөө бусдаас шан харамж авахгүй байх баталгааг гаргуулан авч, харилцаа хандлагыг сайжруулах талаар 4 цагийн багц сургалтыг явуулсан.

2016 оны 01 дүгээр улиралд сахилга, ёс зүйн зөрчил гаргасан 6 алба хаагчийг сахилга ёс зүйн зөвлөгөөнөөр оруулж, хугацаатай үүрэг өгч, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар амлалт, баталгааг гаргуулан авч, энэ төрлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цаашид ийм зөрчилд алба хаагч холбогдохгүй байлгах үүднээс мэдээлэл бэлтгүүлэн хүргүүлсэн нь ихээхэн шинэлэг бусдад хүрсэн ажил болсон.

Хэлтсийн алба хаагчдын харилцааны соёлд онцгой анхаарч, иргэдтэй соёлч, албаны нэр хүндийг өндөрт өргөн харилцаа хандлагаа сайжруулж байгууллагын соёлыг түгээж ажиллахаар салбар төлөвлөгөөг гарган тодорхой ажлуудыг шат дараатай хийж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 31 ны өдрийн А/127 тоот тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд “Сахилга ёс зүйг сайжруулах дэд хөтөлбөр” батлагдсаныг танилцуулж, хэлтсийн хэмжээнд сахилга хариуцлагыг сайжруулах 20 заалттай төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэнд хяналт тавьж ирлээ.

2016 оны 01 дүгээр улиралд Засгийн газрын 11-11 төвд иргэн Энхболдоос хэлтсийн алба хаагч нарт гэмт хэргийг шуурхай илрүүлсэнд талархлыг хамт олонд танилцуулан, алба хаагч нарыг шагнаж урамшуулан, иргэн Бээжингээс цагдаагийн алба хаагчийн зан харилцааны талаар гаргасан гомдолд албаны

шалгалт явуулж, буруутай алба хаагчид сануулга өгч хариуг хүргүүлсэн.

Дээд газраас ирүүлсэн алба хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах талаар ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг Мягмар, Пүрэв гарагийн мэдээллийн цагаар алба хаагчдад мэдээлж, хэрэгжүүлэх ажлын салбар төлөвлөгөөг тухай бүрт нь гарган биелэлтийг дүгнэж ирсэн.

Хэлтсийн нийт бие бүрэлдэхүүний 60 хувийг бүрдүүлдэг ахлагч бүрэлдэхүүний сахилга, хариуцлага, ажлын үр дүн, хамт олны нэгдмэл уур амьсгалыг бүрдүүлэх, албаны бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор “Ахлагчийн зөвлөл”-ийг байгуулан дүрэм, ажлын төлөвлөгөөг батлан ажиллах нөхцөл бололцоог хангаж өгсөн.

Байгууллагын соёл нь зөвхөн алба хаагч нарын харилцаа хандлага, сахилга ёс зүйгээс гадна, харилцах байгууллагууд рүү хүргүүлж байгаа албан бичгийн төлөвлөлт, иргэд байгууллагад хүргэж байгаа үйлчилгээний стандарт, соёлыг түгээх олон талт ажиллагаа болон, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах байдаг тул, сурталчлах аяныг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Цагдаагийн алба хаагчийн албаны бэлэн байдал, онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадвар, тусгай хэрэгсэл агсамж, биеийн хүч хэрэглэх чадварыг олгох дадлагажуулах, сэтгэл зүйг бэлтгэх үүднээс 2016 оны 1 дүгээр улиралд албаны бэлтгэлийн хичээлийг 2 удаа, бэлэн байдлыг 1 удаа шалгаж зааварчилсан.

#### **Сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх гэсэн гуравдугаар зорилтын хүрээнд:**

Тус хэлтсийн 2016 оны албаны сургалтыг ЦЕГ-ын даргын 2016 оны б/106 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын 2016 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”, ЦЕГ-ын Тэргүүн дэд даргын 2015.11.30-ны өдөр баталсан “Цахим сургалтын удирдамж”, Цагдаагийн байгууллагаас Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр 2016 онд хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, Төмөр зам дахь цагдаагийн хэлтсийн даргын баталсан хэлтсийн 2016 албаны сургалтын төлөвлөгөөг удирдлага болгон зохион байгууллаа.

Тус хэлтсийн танхимын сургалтыг дараахь 4 үндсэн чиглэлээр зохион байгуулсан бөгөөд

- Алба хаагчийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг 12 удаа 24 цаг 1066 алба хаагч
- Мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтыг 10 удаа 20 цаг 798 алба хаагч
- Мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах сургалтыг 10 удаа 20 цаг 817 алба хаагч

Түүнчлэн ажлын байран дээрх танхимын сургалтад аудио бичлэг 10 удаа ашиглаж, сургалтын зохиомол орчинг 2 удаа бүрдүүлсэн бөгөөд сургагч багш болон тасгийн даргаас дээшхи албан тушаалтан 11 удаа сургалт орж 1153 алба хаагч хамрагджээ.

2016 оны Нэгдүгээр улирлын байдлаар тус хэлтсийн алба хаагчдаас

- ✓ 11 алба хаагч ХСИС-ийн эчнээ ангид,
- ✓ 1 алба хаагч магистрын сургалтанд,
- ✓ 1 алба хаагч докторын сургалтанд,
- ✓ 1 алба хаагч англи хэлний дунд шатны сургалтанд

- ✓ 3 алба хаагч албан тушаалын сургалтанд
- ✓ 14 алба хаагч бусад сургалтанд тус тус хамрагджээ.

Үүнийг дурьдвал:

- ЦЕГ-ын хүний нөөцийн цахим сангийн программын шинэчлэлийн сургалтанд хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Г.Баярцэцэг
- ХСИС-ийн Ахисан шатны боловсролын сургуулийн Англи хэлний дунд шатны сургалтанд мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Б.Ариунтунгалаг
- Гэмт хэрэгтэй тэмцэх албанаас зохион байгуулсан хэрэг журтгэгч нарын сургалтанд ахлах хэрэг бүртгэгч, цагдаагийн хошууч Б.Намнандорж, цагдаагийн дэслэгч Э.Тулга
- ХЗЯ-аас зохион байгуулсан “Хууль сахиулах салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо” сургалтанд хэв журмын ахлах байцаагч, цагдаагийн ахмад Д.Өнөртөгс
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон болон архи согтууруулах ундаа хэрэглэн сахилга ёс зүйн зөрчил гарган сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчдын давтан сургалтанд ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Б.Пүрэвжав, хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч О.Өсөхбаяр, хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч М.Хүрэлбаатар, цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Б.Энхжаргал, Т.Сэргэлэн, цагдаагийн ахлагч Ц.Мөнгөнбаяр нар
- Харилцаа ёс зүйн зөрчил гарган сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчдын давтан сургалтанд цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Г.Очирбат, цагдаагийн ахлагч З.Нямрагчаа нар тус тус хамрагдсан байна.

Мөн ЦЕГ-ын Сургалтын төвөөс ирүүлсэн албан бичгийн дагуу 2016 оны Хоёрдугаар улиралд сургалтанд хамрагдах 37 алба хаагчийн нэрсийг гарган хүргүүлсэн бөгөөд Цахим сургалтын хүрээнд эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Д.Мөнхбат “АСАР” сан болон бусад программтай ажиллах ажиллагаа”, мэдээлэл судалгааны мэргэжилтэн Б.Өнөр “Цагдаагийн байгууллагын түүхэн хөгжил”, Саатуулах байрны дарга, цагдаагийн хошууч Ө.Баярмаа “Архины хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх” сэдэвт видео хичээлүүдийг тус тус хариуцан зайны сургалтаар орсон байна.

ЦЕГ-ын ХНСХ-т хятад хэлний анхан шатны сургалтанд хамруулахаар 3 алба хаагч, англи хэлний гүнзгийрүүлсэн шатны сургалтанд хамруулахаар 1 алба хаагчийн нэрийг дэвшүүлэн албан тоот хүргүүлэн ажиллав.

**Хоёр: Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Цагдаагийн төв байгууллагын даргын болон аймаг, нийслэл, дүүргийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн**

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 16 заалт бүхий салбар төлөвлөгөө, Цагдаагийн байгууллагаас 2016 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс хийж гүйцэтгэхээр заагдсан заалтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах ажлын арга барилыг боловсронгуй болгох, бүрэлдэхүүний сахилга, ёс зүйг дээшлүүлэх, тэдний дунд зохиох сургалт, соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах зорилгоор 68-н заалт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан биелэлт үр дүнг тогтоосон хугацаанд хангуулахаар ажиллаж байна.

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2016 оны 02-р сарын 06-ны өдрийн өгсөн үүргийг хэрэгжүүлэх 32 заалттай, ЦЕГ-ын дэд даргын 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 3/23 тоот албан үүргийг хэрэгжүүлэх 10 заалттай, Мөрдөн байцаах газрын 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх 5 заалттай, Эрүүгийн цагдаагийн газрын 6 дугаар хэлтсийн даргын 2016 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10ё/838 тоот алба даалгаврыг хэрэгжүүлэх 8 заалттай, Замын цагдаагийн газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 12/59 тоот үүрэг ажлын чиглэлийн дагуу 8 заалттай төлөвлөгөөг тус тус боловсруулан хэрэгжилтийн явцыг тогтоосон хугацаанд тайлагнахаар ажиллахын зэрэгцээ бие бүрэлдэхүүний дунд хамт олонч уур амьсгалыг өрнүүлэх, бие биендээ зүй ёсны шаардлага тавьдаг, иргэдийг хүндэлдэг, үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд шударга байх зарчмыг баримтлан ажиллаж хэвшлээ.

Тус цагдаагийн хэлтсийн даргын дэргэдэх зөвлөлийн хурал 2016 оны 01 дүгээр улиралд 7 удаа хуралдсан байна. 2016 оны 01 дүгээр сард офицер бүрэлдэхүүнд орох, ахлах болон түүнээс дээш албан тушаалын нөөцөнд авч алба хаагчдын нэрсийг хүргүүлжээ. Хэлтсийн даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар алба хаагчдын томилгоотой холбоотой 9, нийгмийн асуудалтай холбоотой 1, албаны шалгалттай холбоотой 2, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 7, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 1, ахмад настантай холбоотой 1, ажлын үр дүнтэй холбоотой 3 асуудлыг хэлэлцээд байна.

Тус цагдаагийн хэлтсийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Б.Ангара, цагдаагийн дэд ахлагч Т.Пүрэвжаргал нарын хашаа байшин шатсан тул алба хаагчдын дундын сангийн хуримтлалаас тус бүр 300,000 төгрөгний тусламж үзүүлээд байна.

**Гурав: Үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, мэдээллийг тайлагнах чиглэлээр авсан арга хэмжээ, үр дүн**

ЦБҮАЖ-ын код 110 –ын дагуу Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үр дүнгийн үнэлгээг гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэсэн 3 –н чиглэлээр гарган хүргүүлсэн.

Хэлтсийн хэмжээнд үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт өгч ажилласны дүнд гэмт хэргийн илрүүлэлт 78.4 хувь, учирсан хохирлын нөхөн төлүүлэлт 83,8 хувь болж үндсэн ажлын үр дүн өмнөх жилээсээ ахисан үзүүлэлттэй гарсан.

ЦЕГ-ын Төмөр зам дахь цагдаагийн хэлтсээс 2015 онд “Хэрэглэгчийн үнэлгээ”-ний санал асуулгыг өөрийн хэлтсийн үйл ажиллагааны онцлогтой нийцүүлэн 8 хаалттай, 2 нээлттэй, 41 үзүүлэлт бүхий санал асуулгын хуудсаар Улаанбаатар төмөр замын харъяа байгууллагуудад зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээний хүрээнд 199 төмөр замчин, ажилчдаас авч дүнг нэгтгэн дээд газарт хүргүүлсэн.

**Дөрөв: Шүүх прокурорын мэдэгдэл, энгийн магадлалын дагуу авсан арга хэмжээ, үр дүн**

Цагдаагийн хэлтсийн алба хаагчдаас 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, хэрэг бүртгэх эрх бүхий алба хаагчдын хуулийг хэрэглэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор албаны сургалтуудыг

явуулж, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хууль зөрчиж прокурорын мэдэгдэл шаардлага аваагүй байна.

**Тав:** Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээлэл

### **Нэг. Гэмт хэрэг, зөрчлийн талаархи гомдол мэдээлэл**

#### **1.1. Хүлээн авч шалгасан нийт гомдол мэдээлэл:**

- Урьд оны үлдэгдэл 3, тухайн оны 167 нийт 170 гомдол мэдээлэл шалгасан: Үүнд эрүүгийн албанаас эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар 10, харъяаллын дагуу 2,



Нийт 155 гомдол мэдээлэл шийдвэрлэсэнээс

- 94 буюу 61 хувийг гэмт хэргийн,
  - 5 буюу 3 хувийг бусад,
  - 56 буюу 36 хувийг зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байна.
- #### **1.2. Гэмт хэргийн талаархи гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдал:**
- 31 буюу 33 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэсэн,
  - 63 буюу 67 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан, тэдгээрээс гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлтэй 63 байна.
- #### **1.3. Гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаа:**
- 53 буюу 56 хувийг 5 хоногт,
  - 41 буюу 44 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн байна.
- #### **1.4. Зөрчлийн талаархи гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдал:**
- 54 буюу 96 хувийг шийтгэврээр торгож,
  - 2 буюу 4 хувийг зөрчлийг хянан шалгаж шийдвэрлэх боломжгүй үндэслэлээр шийдвэрлэсэн.
- #### **1.5. Нийт зөрчлийн талаархи гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаа:**
- 56 буюу 100 хувийг 14 хоногт шийдвэрлэсэн байна.
- #### **1.6 Бусад шийдвэрлэлт:**

-5 гомдол, мэдээллийг газар дээр нь захиргааны арга хэмжээ авсан үндэслэлээр


шийдвэрлэсэн байна.

### **Хоёр. Бүртгэгдсэн гэмт хэрэг**

#### **2.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг**

- Хэлтсийн хэмжээнд эхний 3 сард 30 гэмт хэрэг бүртгэгдсэн. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1 буюу 3,4 %-аар өссөн байна..


## 2.2. Гэмт хэргийн ангилал өсөлт, бууралтаар:




## 2.3. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэргийн төрлөөр:



## 2.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн гариг:



## 2.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг:



## 2.6. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал

- Нийт гэмт хэргийн 6 нь согтуугаар, эмэгтэй хүн оролцсон 6, бүлэглэн гүйцэтгэсэн 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.



## 2.7. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

### Гурав. Гэмт хэргийн илрүүлэлт

#### 3.1. Гэмт хэргийн илрүүлэлт:

- Гэмт хэргийн илрүүлэлт 71.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар өссөн.

#### 3.2. Илрүүлэлт гэмт хэргийн ангилал, хувиар:





### 3.3. Бүтгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг:



### 3.4. Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн төрөл

-Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх -1,

-Бусдын эд хөрөнгийг хулгайлах-2,

-Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах-1 гэмт хэрэг илрээгүй байна. Дээрхи хэргүүдээс гадна өмнөх онуудын эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 12 хэрэг түдгэлзүүлээстэй байна.


#### **Дөрөв. Гэмт хэрэгт холбогдогчид**

##### 4.1. Гэмт хэрэгт холбогдогчид:

Нийт 26 хүн /өмнөх оны мөн үеэс 8-р буюу 23,5 %-аар буурсан/ гэмт хэрэгт холбогдсоны:


- 8 эмэгтэй буюу 31 хувийг эзэлж байгаа нь урьд оны мөн үеэс 2 буюу -20 хувиар буурсан байна.
- Урьд оны мөн үед 18 хүртэл насны хүүхэд холбогдсон хэрэг 4 гарч байсан бол энэ онд холбогдоогүй байна.

##### 4.2. Гэмт хэрэгт холбогдогчид насны ангиллаар:



##### 4.3. Гэмт хэрэгт холбогдогчдын

нийгмийн байдал




**Тав. Гэмт хэргийн хохирогч, хохирол**

5.1. Гэмт хэргийн улмаас:


- 28 иргэн хохирсон, /эмэгтэй-15/
- Нас барсан 2
- Гэмтсэн хүн 9 байна

5.2. Гэмт хэрэгт хохирогчид насны ангиллаар:



5.3. Гэмт хэргийн улмаас учирсан эд

хөрөнгийн хохирол



Мөрдөн байцаалтын шатанд нийт хохиролынхоо 97,2 % төлүүлсэн бол Хэрэг бүртгэлтийн шатанд 84,5 % нөхөн төлүүлсэн байна. Хэлтсийн нийт хохирол нөхөн төлүүлэлт 93,5 % байна.

#### 5.4 Гэмт хэргийн шийдвэрлэлт

Урьд оны үлдэгдэл 6, тухайн онд шинээр дугаар авсан 31, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 5, нийт 42 хэрэг шалгаснаас 25 хэрэг хэрэгсэхгүй болгох саналтай, 2 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлж, 1 хэрэг нэгтгэснээс хорогдсон, 6 хэргийг шинээр түдгэлзүүлсэн байна. Одоо 8 хэргийн үлдэгдэлтэй байгаагаас МБ шатанд-5, ХБ шатанд 3 байна.

#### **Зургаа. Захиргааны зөрчил**

##### 6.1. Шалгасан захиргааны зөрчил:

- нийт 5225 захиргааны зөрчил бүртгэгдсэн,
- өмнөх оны мөн үед 4200 байснаас 1025 нэгжээр буюу 24,4 хувиар өссөн.
- 5201 иргэнийг 85 сая 571,8 мянган төгрөгөөр торгосны 2387 зөрчил нь /11 сая 935,0 мянган төгрөг/ торгуулийн тасалбараар, 2814 зөрчил нь /73 сая 636,8 мянган төгрөг/ бэлэн бусаар торгожээ.
- Шийтгэврээр 76 хүнийг 2 сая 845,2 мянган төгрөгөөр торгосон байна.
- Торгуулийн хуудсаар 37 гадаадын иргэнийг 185 мянган төгрөгөөр торгосон байна.

##### 6.2. Захиргааны зөрчлийг шийдвэрлэсэн албан тушаалтан:

- Цагдаагийн алба хаагч 56 захиргааны зөрчил шийдвэрлэсэн байна.

##### 6.3. Захиргааны зөрчлийн улмаас учирсан хохирол:

- Нийт 5887,6 мянган төгрөгний хохирол учирснаас 5663,4 мянган төгрөгийн хохирлыг нөхөн /96,2 % / төлүүлсэн байна.


##### 6.4. Шийтгэврээр захиргааны шийтгэл ногдуулсан хууль тогтоомж:

- 17 буюу 30 %-ийг ЗХТХ-аар,
- 46 буюу 64 %-ийг ЗХАБТХ-аар,
- 7 буюу 6 %-ийг ТХТХ-аар тус тус шийтгэл ноогдуулсан байна.

##### 6.5. Захиргааны хариуцлагын тухай хуулиар шийтгэврээр арга хэмжээ авсан байдал:

- Танхайрах 4,
- Галт тэрэгний АБ, ашиглалтын журам зөрчих 10,
- ЦАХ-ийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх 3

##### 6.6. Захиргааны хариуцлагын тухай хуулиар торгуулийн хуудсаар арга хэмжээ авсан байдал:



### 6.6. Захиргааны зөрчил үйлдэгдсэн газар, зөрчлийн тоо:



-зам дээр үйлдэгдсэн 31 зөрчлийн 29 нь төмөр замын гарам,

-олон нийтийн газар үйлдэгдсэн 2 зөрчил нь төмөр замын буудал ,

-нийтийн тээвэрт үйлдэгдсэн 1 зөрчил нь галт тэргэнд дээр үйлдэгдсэн байна.

### 6.7. Бүртгэгдсэн захиргааны зөрчлийн үйлдэгдсэн өдөр:

- 7 нь Даваа гаригт
- 5 нь Мягмар гаригт
- 9 нь Лхагва гаригт
- 8 нь Пүрэв гаригт
- 6 нь Баасан гаригт
- 4 нь Бямба гаригт
- 8 нь Ням гаригт үйлдэгдсэн байна.

### 6.8. Бүртгэгдсэн захиргааны зөрчлийн үйлдэгдсэн цаг:

- 06-12 цагт 16,
- 13-18 цагт 18,
- 19-24 цагт 7,
- 01-05 цагт 6 зөрчил тус тус үйлдэгдсэн байна.

### 6.9. Бүртгэгдсэн захиргааны зөрчил үйлдэгдсдийн онцлог:

- 6 нь согтуугаар ,

- 5 нь эмэгтэй хүн оролцсон ,
- 2 нь хүүхэд оролцсон байна.

#### 6.10. Эрүүлжүүлэх үйл ажиллагаа:

- 665 хүн эрүүлжүүлж 2737,85 мянган төгрөгийн үйлчилгээний хөлс авсан байна.
- 1 хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулсан.

#### 6.11. Туслах тоо бүртгэлийн судалгаа:

- Эмзэг цэгийн объектын судалгаанд-3,
- Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгжийн судалгаанд-3,
- Гэмт хэрэгт уруу татагчийн судалгаанд-1,
- Гэмт хэрэгт холбогдож, өртөж болзошгүй этгээдийн судалгаанд-76,
- Сэтгэл мэдрэлийн өвчтэй хүний судалгаанд-1,
- Архаг архичдын судалгаанд-5 тус шивэгдсэн байна.

Нийт объектын судалгаанд-6, субъектын судалгаанд-83 баяжилт хийгдсэн байна.

#### **Зургаа: Санхүү, нийгмийн асуудлын талаар хэрэгжүүлсэн ажил**

2016 оны I улиралд улсын төсвөөс санхүүжилт 277.639,4 төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого буюу цагдаагийн алба хаагч гэрээгээр ажиллуулах гэрээний орлого, бусад орлого 363.307,6 төгрөг нийт 640.947,0 төгрөгийг төвлөрүүлэн 589.344,8 төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан. Үүнд:

Цалин хөлс нэмэгдэл урамшилд: Үндсэн цалин, нэмэгдэл цалинд 302.499,9 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх ЭМД, НДШ-д 6.849,9 төгрөг.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: гэрэл цахилгааны зардалд 2.449,5 төгрөг, халаалтын зардалд 4.826.3 төгрөг, цэвэр бохир усны зардалд 1.523,1 төгрөг.

Хангамж бараа материалын зардал:  $\text{à} \div \text{è} \text{á} \text{ó} \text{ð} \text{à} \text{è} \text{é} \text{í} \text{ç} \text{à} \text{ð} \text{à} \text{à} \text{è} \text{ä} \text{225,0} \text{ ò} \text{°} \text{ã} \text{ð} \text{°} \text{ã}$ ,  $\text{ø} \text{ó} \text{ö} \text{ä} \text{ä} \text{í} \text{õ} \text{í} \text{é} \text{á} \text{í} \text{í} \text{í} \text{ú} \text{ç} \text{à} \text{ð} \text{à} \text{à} \text{è} \text{ä} \text{1.267,8} \text{ ò} \text{°} \text{ã} \text{ð} \text{°} \text{ã}$ , Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 549,9 төгрөг.

Нормативт зардал: Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 99,8 төгрөг, Хоол, хүнсэнд 2.936,4 төгрөг,

Бараа, үйлчилгээний бусад зардал: Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 93,6 төгрөг

Харуул хамгаалалтын зардал: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсөнд 255.968,2 төгрөг тус тус зарцуулсан


Цагаан сараар ахмадыг хүлээн авахад давхардсан тоогоор 84 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэхэд 661,5 төгрөг зарцуулсан.

#### **Санхүүгийн 2014 2015, 2016 оны 1-р улирлын харьцуулалт:**

##### **Орлого:**

Үзүүлэлт	2014 он 1 улирал	2015 он 1 улирал	2016 он 1 улирал
Төсвийн санхүүжилт	279313800,00	338943600,00	277639400,00
Системийн дотоод тооцоо	2094200,00	485600,00	267400,00
Үндсэн үйл ажиллагааны орлого	255023374,00	310761198,30	354890916,70


### Орлого/графикаар/



### Зардал:

Үзүүлэлт	2014 он 1-р улирал	2015 он 1-р улирал	2016 он 1-р улирал
Цалин хөлс, нэмэгдэл, НДШ, ЭМД /Үр дүнгийн тайлан/	430100077,00	544018484,00	546195365,00
Урсгал зардал:	54481605,14	428277761,33	624323398,59
Бусад зардал	0,00	0,00	0,00


### Зардал/графикаар/



**Хөрөнгө:**

Үзүүлэлт	2014 оны 1-р улирал	2015 оны 1-р улирал	2016 оны 1-р улирал
Бараа материал	134199869,00	137489842,90	138262193,80
Үндсэн хөрөнгө	197606951,50	173317902,80	158165159,6
Нийт хөрөнгө - /өглөг авлагаас бусад/	336300401,20	365179824,20	329795232,20

**Хөрөнгө /графикаар/**



**Гэрээт харуул хамгаалалтын зардал:**

2016 оны 1-дүгээр сарын 01-ны өдөр УБТЗ нийгэмлэгтэй байгуулсан гэрээний төсвөөр 95 офицер, цагдаа ажиллуулахаар 1.229.018,2 төгрөгийн гэрээг хийсэн. 2016 оны 03 сарын 31-ны байдлаар 307.254,5 төгрөгийн санхүүжилт авахаас 352.024,8 төгрөгийн санхүүжилт авсан.

### **Торгууль, шийтгэвэр:**

2016 оны жилийн эхэнд 5000 төгрөгний 88 төгрөгний үнэтэй 563 ширхэг торгуулийн хуудас, 110 төгрөгний үнэтэй 94 ш шийтгэвэрийн үлдэгдэлтэй байсанаас 1-3 сард Торгуулийн тасалбар 3000 ширхэг орлого авч, 2251 ширхэг торгуулийн хуудсаар 11.255,0 төгрөгийн орлого 54 ширхэг шийтгэвэр зарлага болгож 1.918,2 төгрөгийн орлого нийт 13.173,2 төгрөгийн орлогыг ЦЕГ-ын торгууль шийтгэврийн дансанд төвлөрүүлж ажиллаа.

### **Долоо: Бусад ажлын талаар:**

Төмөр зам дахь цагдаагийн хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүдээ, эдийн засгийн агаар хэсгийн төлөөлөгч нар 2016 оны 1-р улиралд нийт 80 мэдээ, мэдээлэл олж шалган 38 холбогдогчтой 1 тэрбум 138,5 сая төгрөгний хохиролтой 30 гэмт хэрэг үйлдэл илрүүлэн холбогдох албанд эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар материалыг шилжүүлэн ажилласан байна.

Цагдаагийн байгууллагын “Эрэн сурвалжлах ажлын “ASAP” санд тус хэлтсээс оргодол 1, хэн болох нь тогтоогдоогүй цогцос 2, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 5, эд зүйлс 4, , нийт 12 эрэн сурвалжлах хүн, цогцос, эд зүйлсийн мэдээлэл бүртгэгдэж зарлагдсан ба үүнээс оргодол 1, хэн тогтоогдоогүй цогцос 2, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 5 эд зүйл 1, нийт 9 мэдээллийн эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

1. Тус хэлтсээс эрүүгийн 201624000163 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000011 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 25 настай Гомбожав овогтой Энхбат РД:/УП91031509/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

2. Тус хэлтсээс гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000004 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 53 настай Гончиг овогтой Даваасүрэн РД:/ Н362022675 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

3. Тус хэлтсээс гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000002 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 23 настай Төмөрбаатар овогтой Хулан РД:/ЕЙ92080802/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

4. Тус хэлтсээс гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000011 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 29 настай Хүрэлбаатар овогтой Майцэцэг РД:/ЕА86050108/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

5. Тус хэлтсээс гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000025 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 23 настай Батбаяр овогтой Батсүрэн РД:/СЧ92082236/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

6. Тус хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000005 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 53 настай Рэнцэнханд овогтой Рэгзэдмаа РД:/ УО63072951 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,



7. Тус хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000012 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 53 настай Бямбадорж овогтой Буянхишиг РД:/ ЕЙ95112908 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

8. Тус хэлтсээс оргодлоор “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000010 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 23 настай Батбаяр овогтой Батсүрэн РД:/СЧ92082236/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

9. Тус хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000010 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн газар хэлтсээс Цагдаагийн байгууллагын “Эрэн сурвалжлах “ASAP сан”-д бүртгэгдэж зарласан гэрээсээ гараад сураггүй алга болсон 2 олж тогтоон нутаг дэвсгэрийн цагдаагийн хэлтсүүдэд хүлээлгэн өгч ажилласан байна.Үүнд:

1.БЗД-ийн цагдаагийн 1-р хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540005313000350 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 20 настай Цогтгэрэл овогтой Батсолонго РД:/ СЮ93032506 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

2.СХД-ийн цагдаагийн 3-р хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540006316000361 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 27 настай Батбуян овогтой Уранчимэг РД:/ ТК88081401 /-ыг тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоож ажилласан.

### **Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн сэтгэл зүйчийн зүгээс:**

- Ажлын нөхцөл байдал, амьдрал ахуйн талаарх сэтгэл зүйн тандалт ярилцлагыг давхардсан нэрээр 114 алба хаагчтай хийв.
- Нэр бүхий 5 алба хаагчийн ар гэртэй уулзаж гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөөг утсаар болон биечлэн өгч ажиллав.
- Тус хэлтсийн “Хэрэглэгчийн үнэлгээ”-ний 2015 оны тайланг гарган эх материалыг товъёоглон хавтаслан ЦЕГ-ын ДХАБГ-т 27а/2009 албан бичгээр хүргүүлж, 2014 оны үзүүлэлтүүдтэй харьцуулсан судалгааг хийж, танилцуулгыг хэлтсийн даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулав.
- Сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргасан 4 алба хаагчтай шалтгаан нөхцлийг тогтоох, сэтгэл зүйн хямрал, гутрал байсан эсэх талаар болон тайвшруулах ярилцлага хийн, мэдээлэл хийх хуваарь, сэдвийн хамт өгөн 2 алба хаагч мэдээлэл хийв.
- Тус хэлтэст шилжин ирэх хүсэлт гаргасан 2, цагдаагийн байгууллагад анх удаа орохоор хүсэлт гаргасан 5 иргэнтэй сэтгэл зүйн онцлог тодорхойлох ярилцлага хийн, бие хүний сэтгэл зүйн чанар, сэтгэл хөдлөл мэдрэмж, ёс зүйн харилцаа, оюун ухааны чадварын төвшинг тодорхойлох сорил авч дүгнэн, сэтгэл зүйн тодорхойлолтыг холбогдох ажилтанд өгч ажиллав.
- ЦЕГ-ын ХНСХ-ийн мэдэлд “Төрийн тусгай албаны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд орж ажиллан сэтгэл зүйн сорил авах, боловсруулах, ярилцлагын дүгнэлт гаргахаар 37 иргэнтэй ярилцлага хийн, дүгнэлтийг гаргав.
- ЦЕГ-ын харъяа байгууллагуудын удирдах ажилтан, дарга нарын мэргэжлийн төвшинг тогтоох ажлын хэсэгт орж ажиллан 8 газар хэлтсийн 75 удирдах ажилтны

- 4 төрлийн сэтгэл зүйн судалгааны дүнд боловсруулалт хийж дүгнэлтийг хугацаанд чанартай хийж гүйцэтгэсэн.
- ЦЕГ-ын Хуулийн хэлтсээс ирүүлсэн 2г/352 тоот албан бичгийн дагуу ЦБҮАЖ, түүний хэрэгжилтэнд мониторинг хийх зорилго бүхий санал асуулгын хуудсыг 74 алба хаагчаас авч дүнгийн нэгдсэн түүврийг хийн эх материалын хамт 27а/116 тоот албан бичгээр хүргүүлж ажиллав.
  - Тус хэлтсийн удирдах ажилтнуудын арга барил, шударга байдлын түвшингийн үнэлгээний 3 нээлттэй, 1 хаалттай 70 асуудал тодруулах бүхий санал асуулгын хуудсыг 151 алба хаагчаас авч дүнгийн талаарх нэгдсэн илтгэх хуудсыг хэлтсийн дарга болон дэд даргад, удирдах ажилтан бүрийн дүнгийн талаарх илтгэх хуудсыг зөвлөмжийн хамт хэлтэс, тасгийн дарга нарт өгч ажиллав.
  - ЦЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу алба хаагчдын сэтгэлгээний хэв маяг болон бие хүний зан чанарыг тодорхойлох тестийг 186 алба хаагчаас аван дүнд боловсруулалт хийн сэтгэл зүйн нэгдсэн судалгаанд нэгтгэн Төлөвлөлт зохион байгуулалтын тасгийн 10, ЭЦТ-ийн 16, ХБМБТ-ийн 9, Саатуулах байрны 12 нийт 47 алба хаагчийн сэтгэл зүйн тодорхойлолтыг хүн тус бүрээр гарган, сэтгэл зүйн хувийн хэргийн баяжилтыг хийв.

### **Эрүүгийн цагдаагийн тасгийн Жижүүрийн шуурхай удирдлагын хэсгээс:**

ЦБҮАЖ-ны код 200.4.4. 202-т заасны дагуу албан байгууллага, иргэдээс 103 мэдээ мэдээлэл, дуудлага хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 50, захиргааны зөрчлийн шинжтэй 53 дуудлага мэдээлэл хүлээн авсан. ЦБҮАЖ-ын код 201.5.6 заасны дагуу төвөөс сүлжээгээр гэмт хэргийн 2975, хүн болон эд зүйл эрэн сурвалжилсан 971 зарлан мэдээлэл хүлээн авч, эргүүл постонд дамжуулан эрэн сурвалжлах ажиллагаа зохион байгуулж ажилласан.

Унгар улсын ерөнхий сайд Виктор Орбан Монгол улсын хийсэн төрийн айлчлал хийх үеийн хамгаалалтанд батлагдсан төлөвлөгөө хуваарийн дагуу аюулгүй байдлыг хангаж, нөхцөл байдлын талаар ЦЕГ-ын ШУШтабд болон шонхортой тухай бүр холбогдож ажилласан ба хамгаалалтын үеэр алба хаагчдаас ямар нэг зөрчил дутагдалгүй хэвийн ажилласан.

Саатуулах байр нь 2016 оны 1-р улиралд архидан согтуурч, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 663 эмэгтэйг хүлээн авч саатуулсанаас 644 хүнээс 2,725,400 төгрөгний төлбөр гаргуулахад хяналт тавьж хэлтсийн хоногийн мэдээнд тусган ажилласан. УБТЗ-н ГУА-ийн жижүүрийн утас 244078, Хөдөлгөөн зохицуулах жижүүрийн 244119, 244610 дугаарын утастай тогтмол холбоотой ажиллаж мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

### **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар:**

Цагдаагийн байгууллагаас 2016 онд хэрэгжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тасаг албадаас төлөвлөгөөнд тусгуулах саналыг авч нэгтгэн Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг улаанбаатар төмөр замын гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга, төмөр зам дахь цагдаагийн хэлтсийн дарга нарын баталсан 7 бүлэг 45 зүйлтэй төлөвлөгөө боловсруулан биелэлтийг ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2011 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа”, Монгол улсын Засгийн газрын 2012 оны 252 дугаар тогтоолоор батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцон ажиллаж байна.

2016 онд Гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний тусгагдсан ажлын хүрээнд хийгдэх төсвийг батлуулан ажиллаж байна.

Төлөвлөгөөнд заагдсаны дагуу 2015 онд гэмт хэрэг, зөрчилгүй байгууллагаар шалгарсан Улаанбаатар өртөө, Толгойт өртөө, Авто вокзал, Ган зам пресс, Ус хангамж эрчим хүчний 1 дүгээр анги, Дохиолол холбооны 2 дугаар анги, Төв засврын газар зэрэг 7 байгууллагад “Батламж”, дурсгалын зүйлээр, олон нийтийн эргүүлд идэвхи санаачлагатай бусдыгаа хошуучлан ажилласан Хангамжийн албаны жолооч Д.Банди, хэв журмын офицер, цагдаагийн ахлах дэслэгч Т.Энхтүвшин, Улаанбаатар татах хэсгийн хүний нөөцийн албаны менежр Ө.Энхбаатар, хэв журмын офицер, цагдаагийн ахмад Ц.Энхтайван, Дохиолол холбооны 2 дугаар ангийн жолооч С.Бадамраа, ахлах хэрэг бүртгэгч, цагдаагийн хошууч Б.Намнандорж нарыг тус бүр 90,000/ ерэн мянган төгрөгөөр шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулсан.

Монгол улсын Засгийн газрын 2007 оны 13 дугаартай албан даалгавар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны 125 дугаар тушаалаар сар бүрийн 2 дахь долоо хоногт нээлттэй өдөр” Монгол улсын ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Монгол улсын засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулахаар тасаг албадын хуваарь гарган ажиллаж байна.

Монгол улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжилтийг эрчимжүүлэх, цагдаагийн байгууллагын үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх, улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудал болон олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчил гаргуулахгүй байх урьдчилан сэргийлэх зорилгоор “Сар шинэ”, “Нүүрс”, “Хяналт-1”, “Шалгалт”, “Аюултай бүсийн дэглэм”-ийг сахиулах, эрсдлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаа”, “Аюултай бүс”, зэрэг 6 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион явуулж үр дүнг тооцон ажиллаа.

Тус цагдаагийн хэлтсийн хүлээлгийн танхим болон өртөө, зангилаадын зорчигч үйлчилгээний төв буудлуудад халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье, Иргэдээ эрүүл мэндээ дээдэлж, хуулиа хэрэгжүүллье?, Тамхи татахыг хориглоно, эрчүүд бид хүчирхийллийг зогсоож чадна, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай гэх мэт 8 төрлийн санамж, зурагт хуудас гарын авлагуудыг байршуулж 352 иргэнд тараах материал өгч ажилласан.

Улаанбаатар төмөр замын харъяа 44 байгууллагад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 46 албан мэдэгдэл өгч, 40-д хариуг авсан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, төмөр замын даргатай байгуулсан “Санамж бичиг”-ийн хүрээнд дүүргүүд болон орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдтэй уялдаа холбоогоо сайжруулж хамтран ажиллах зорилгоор нийслэлийн Баянгол дүүрэг дэх цагдаагийн 1,2 дугаар хэлтэс, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн 1

дүгээр хэлтэс, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Баянзүрх дүүргийн цагдаагийн 1,3, дугаар хэлтсийн нийтийн хэв журам хамгаалалх тасгийн дарга, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах байцаагч, тухайн нутаг дэвсгэрийн төмөр зам дайран өнгөрдөг хороо хариуцсан хэсгийн байцаагч, улаанбаатар төмөр замын улаанбаатар хот дахь байгууллагуудын төлөөлөл гэх нийт 70 орчим ажилтан алба хаагчдыг оролцуулан “ Төмөр замын аюултай бүсийн дэглэмийг сахиулах, эрсдлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаа сэдэвт сургалтыг 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 10:00-12:00 цаг хүртэл төмөр замын удирдах газрын “Б” зааланд зохион байгуулан ажилласан.

Хэв журмын оифцер, цагдаагийн ахлах дэслэгч Т.Энхтүвшиний хамт Сонгиохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд байрлах 361 гармын орчимд ажиллаж амьдардаг мал бүхий 22 иргэдтэй уулзаж төмөр замын аюултай бүсийн дэглэм болон тэр төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж 3 төрлийн 66 ширхэг гарын авлага материалыг тараан ажилласан. Гал унтраах ангийн 50 гал сөнөөгчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн их эмч Ж.Гантулгаар архины хор хөнөөл, ажлын байрны стрессын талаар, Аялал жуулчлалын товчооны харъяа 9 энгийн харуул, манаач нарт эргүүл, харуулын дүрэмээр, улаанбаатар татах хэсгийн 65 ажилтанд зэрэг 3 байгууллагын 146 иргэнд яриа хийсэн. Цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, малчин иргэдийн хамтын ажиллагааг дээшлүүлэх тэдэнд төмөр замын аюултай бүсийн дэглэм болон учрах эрсдлийг ойлгуулах чиглэлээр дэс дараалсан арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

Улаанбаатар төмөр зам дагуу өртөө, зангилаадад ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч зэрэг 10 алба хаагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон цагдаагийн ерөнхий газрын дарга, төмөр замын дарга нарын баталсан” Санамж бичиг”-ийг хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар 12 заалт бүхий зааварчилгыг хүргүүлэн сар бүрийн 20-ны өдрийн дотор хийсэн ажлыг тайлан мэдээг авч байхаар төлөвлөн мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн эргүүл, харуулын албаны дүрэм”, улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгийн салбар нэгжүүдтэй байгуулсан Түншлэлийн гэрээний дагуу “Олон нийтийн эргүүлийн хуваарийг гарган батлуулж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Амгалан, Толгойт, төвийн гэсэн 3 чиглэлд 2-3 хүний бүрэлдэхүүнтэй эргүүлийг ажиллуулж байна. 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар олон нийтийн эргүүлд 7 офицер, 15 төмөр замчин 7удаа 26 байгууллагыг шалгаж 4 зөрчил илрүүлэн ажилласан. Зөрчил заагдсан 4 байгууллагыг зөрчлийг газар дээр нь засуулсан. Олон нийтийн эргүүлийн үед зөрчил заагдсан байгууллагыг бүртгэл, судалгааг гарган хяналт тавьж ажиллаж байна.

Төмөр зам дахь цагдаагийн хэлтсээс зохион байгуулж буй ажлын талаар болон эмэгтэйчүүдийн архидалт, гамын зөрчил, галт тэргэнд эд зүйлээ мартаж буух, алдах зэрэг тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах ажлуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд олон нийтэд хүргэж

ажлыг хийж гүйцэтгэсэн. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэлтсийн нийт бие бүрэлдэхүүн болон төмөр замын харъяа байгууллагуудын алба хаагч ажилтнуудад Хууль зүйн яамнаас бэлтгэн гаргасан 24 ангид цуврал киног үзүүлсэн, авлигын эсрэг хуулийг хэрэгжилтийг хангахаар Авлигатай тэмцэх газрын сургалт, соён гэгээрүүлэр, урьдчилан сэргийлэх хэлтсийн ажилтан комиссар Дэлгэрбаярыг урьж сургалт оруулж алба хаагчдаас баталгаа авсан. Ган зам сонины 2016 оны 2 дугаар сарын 22, 2016 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн дугаарт эмэгтэйчүүдийн архидалт болон архинаас татгалзая, Төмөр замын аюултай бүсийн дэглэмийг сахиулах, эрсдлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаа сэдэвт сургалт, 2015 онд гэмт хэрэг, зөрчилгүй байгууллага хамт олон болон олон нийтийн эргүүлд идвэхи санаачлагатай сайн ажилласан байгууллага хувь хүний шалгаруулж шагнал урамшил гадуулсан талаар мэдээ, мэдээлэл өгч мөн галт тэргэнд эд зүйлээ алдахаас болгоомжил, төмөр замын аюултай бүсэд зорчихдоо зориулалтын гарц гарамтай газраар үйлчлүүлж байхыг анхаарж сэрэмжлүүлэг [www.shogt.mn.dorgio.mn](http://www.shogt.mn.dorgio.mn) сайтад галт тэргэнд эд зүйлээ хараа хяналтгүй орхисоноос хулгайд эд зүйлээ алдсаныг төмөр зам дахь цагдаагийн хэлтсийн алба хаагчид түргэн шуурхай ажиллаж илрүүлээ иргэд сонор, сэрэмжтэй зорчихыг сэрэмжлүүлж байна зэрэг 3 сайтад мэдээ, мэдээлэл сэрэмжлүүлэг өгч, нийтлүүлж, иргэд олон нийтэд хүргэсэн. Мөн сар шинийн баяр болгоотой холбогдуулан галт тэргээр үйлчлүүлэх иргэдийн хөл хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан иргэд хулгайд эд зүйлээ алдах, галт тэргэнд бууж суухдаа халтирч гэмтэж бэртэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүрстэй сэрэмжлүүлэг хийж C1, tv5, UBS, MNB, TV9 зэрэг телевизээр өдөрт 2-3 удаа хүргэсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг иргэд олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах хүрээнд цагдаагийн ерөнхий газрын дуудлага студи, tv5, 9, nbs телезигүүдээр “Төмөр замын аюултай бүсийн дэглэмийг сахиулах, эрсдлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаа сэдэвт сургалтыг 5 удаа 10 удаагийн давтамжтай олон нийтэд хүргэсэн.

10 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээ, мэдээлэл өгч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр өгөөжийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх ажилд хамтран ажиллаж байна.

Хуулийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн болж байгаатай холбогдуулан удирдлагаас өгсөн үүргийн дагуу тус хэлтсийн үйл ажиллагааг сурталчлахаар 160x60 хэмжээтэй слайдан самбарын бэлтгэн хэвлүүлсэн.

Галын аюулд өртөж эд хөрөнгөөрөө хохирсон тус хэлтсийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Б.Ангара, Пүрэвжаргал нарын талаар Монгол-оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг улаанбаатар төмөр замын гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга Л.Халтарт уламжлан тус бүр 100,000 ширхэг паалк модыг хөнгөлттэй үнээр авч өгсөн. Мөн Жи Эй Си олон улсын байгууллагад хандан ажиллаж байна.

## **Албадан саатуулах байрны ажил, архидан согтуурахаас сэргийлэх ажлын хүрээнд:**

Саатуулах байрны алба хаагчид нь МУ-ын Цагдаагийн байгууллагын тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Захиргааны журмаар албадан саатуулах тухай журам код-623 болон бусад холбогдох хууль тогтоомжууд 2016 онд ЦЕГ-аас дэвшүүлсэн зорилт, саатуулагдаж буй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд газар дээр нь болон эмнэлэг хүртэлх хугацаанд анхан шатны яаралтай тусламж үзүүлэх ажлын хүртээмжийг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Тус хэлтсийн саатуулах байр нь 2016 оны 1 улиралд СБ-ны дарга 1, эмч 4, цагдаа 8, үйлчлэгч 4, жолооч 1, нийт 18 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй ажил үүргээ гүйцэтгэн ажилласан.

Саатуулах байр нь 1 улиралд архидан согтуурч, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 665 эмэгтэйг хүлээн авч саатуулсанаас төлбөр төлөөгүй 19 эмэгтэй, саатуулсан 646 хүнээс 2.737.850 төгрөгний төлбөр гаргуулан санхүүгийн албанд тушааж төлбөр төлөлт 96,6 %- тай, өмнөх оны үеийхтэй харьцуулахад 40 эмэгтэй буюу 5,6%-иар буурч төлбөр төлөлт 4,7%-р буурсан үзүүлэлттэй гарсан байна.

2016 он гарснаас хойш 2 удаа саатуулагдсан 18, 3 удаа саатуулагдсан 1 иргэний талаарх судалгааг мэдээллийн сангаас авсан.

Асран хамгаалагчид нь 20 иргэнийг хүлээлгэн өгсөн. Саатуулагдсан 665 иргэдийн талаархи мэдээлэлийг ЦЕГ-ын Захиргааны тоо бүртгэлийн санд оруулж, хэлтсийн мэдээлэл судалгааны ахлах байцаагч цагдаагийн ахмад Ц.Сайханзоригтой 665 эмэгтэйчүүдийн мэдээлэлийг тулгаж, дугаар давхардсан, мэдээлэл дутуу шивэгдсэн зэрэг асуудлыг тухай бүрд нь засуулж, хяналт тавин ажилласан. Үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид саатуулах байранд саатуулагдах хугацаандаа ЦАХ-ийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй 164 иргэнийг ЗХТХ-ийн 30.2.1 зүйлээр 820.000 төгрөгөөр торгож, төлбөрийг тухай бүрт нь төрийн санд тушааж санхүүд тооцоо нийлж мэдээллийн санд бүртгэсэн. Саатуулагдсан иргэдэд тавих хяналтыг сайжруулж үзлэг шалгалтыг чанартай хийснээр 5 алба хаагч 9 хутга, 1 газ хураан авсан. Саатуулагдсан 665 иргэний хурууны хээ болон зургийг Шүүх шинжилгээний папилон санд оруулж бүртгэл судалгаанд хамруулан ажилласан.

Саатуулагдсан иргэдийн картыг өдөр тутам авч төлбөр төлөлт хугацаандаа төлөгдсөн эсэх, карт бүртгэлт, мэдээллийн сангийн шивэлтэнд хяналт тавьж, цагдаа нарын торгуулийн хуудасыг баталгаажуулан, саатуулагдсан иргэдэд зарцуулсан эм тарианы зарцуулалтыг эмч нараар тогтмол тооллого хийлгэн тайлан мэдээг сар болгон гарган санхүүд өгч тулган, хугацаа дууссан эмийн жагсаалт гарган санхүүжилтээр 100.000 төгрөгний шаардлагатай эм тариа, хэрэгсэл орлогод авч ажилласан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахаас сэргийлэх чиглэлээр “Хяналт шалгалт-2 сар” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж УБТЗ-ын харьяа “Ган Зам” зочид буудал, ресторан, түрээсийн саун, ган зам сүлжээ хүнсний дэлгүүр, Нийтийн хоолны харьяа УБ-Замын үүд чиглэлийн 103,104-р вагон

рестораны үйл ажиллагаанд хяналт тавьж, МУ-ын АСТТХ-ийн санамж байрлуулан ажилласан.

СЭМҮТ-ийн эмч Г.Гантулгаар “Архины хор уршиг” сэдвээр УБТЗ-ын Тасалбарын төвийн 90 ажилтанд сургалт зохион байгуулсан.

2016 оны 1-3 сард саатуулагдсан 663 иргэнд архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлэг, зөвлөмж 50 ширхэгийг тарааж, “Архины хор нөлөө, эмэгтэйчүүдийг эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?” саатуулах байрны эмч нараар өдөр бүр яриа таниулга хийж, эрүүл мэндийн зөвлөгөө болон хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

Архидан согтуурахаас сэргийлэх талаар мэдээ мэдээлэл бэлтгэн “Ган зам” сонин, NBS телевизэд 2 удаа сэрэмжлүүлэг өгсөн.

ЦЕГ, УБХЦГ-аас зохион байгуулсан “Эмнэлгийн анхан шатны тусламж” сургалтанд 4 эмч оролцсон.

Эм импекс концерноос зохион байгуулсан ОУ-ын семенарт 2 алба хаагч хамрагдсан.

Хэлтсийн 192 алба хаагчийн биеийн жингийн индексийг үзэн, судалгааг гаргасан.

### **Замын цагдаагийн албанаас:**

#### **Нэг:Осол зөрчлийн талаар**

2016 оны 01 дүгээр улиралд гудамж замд хуваарийн дагуу 3 офицер, 5 зохицуулагч ажиллаж, нийт 3698 зөрчил илрүүлж, зөрчил гаргасан 3665 хүнийг 85,57,00 төгрөгийн бэлэн бус хэлбэрээр торгож, эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 18, согтуугаар автомашин жолоодсон 28 зөрчил илрүүлэн БГД-ийн замын цагдаагийн тасагт, цагдаагийн нийтлэг үүргээр гарал үүслийн бичиг баримтгүй мах, махан бүтээгдэхүүн, түүхий эд тээвэрлэж явсан 4, АСАP сангаар эрэн сурвалжлагдсан 1 зөрчил тус тус илрүүлэн цагдаагийн хэлтсийн жижүүрийн ахлах офицерт шилжүүлж ажиллаа.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу улсын дугаарын хязгаарлалтын хүрээнд хяналт шалгалт хийж 516 зөрчил илрүүлэн бэлэн бусаар зөрчил гаргасан 516 хүнийг 4,128,000төгрөгөөр торгож ажил, амралтын өдрүүдэд хяналт тавьж ажилласан.

Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан гомдол мэдээлэл 31, зам тээврийн осол 1-г шалган мэдээлэл тогтоогдоогүй 1, шийтгэвэрээр 31 хүнийг 1,334,400 төгрөгөөр торгож хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн.

Хоёр:Зам тээврийн осол зөрчлөөс  
урьдчилан сэргийлэх талаар:

Цагдаагийн хэлтсийн ЭЦТ, ХБ, МБТ-тай хамтран “Сар шинэ”, “Шалгалт” нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж үр дүнг тооцож ажилласан.

Улаанбаатар төмөр замын Замын 2,6-р анги, Авто бааз,нийтийн зорчигч тээврийн Эрдэм транс ХХК, Автобус- 5 ХХКзэрэг байгууллагуудын жолооч нарт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар 5 удаа 5 цагийн сургалт зохион байгуулж, сургалтанд 166 жолооч хамрагдсан.

Авто тээврийн үндэсний төв дээр нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний автобусны жолооч нарын дунд зохиогдсон “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” сэдэвт хамтарсан сургалтанд төмөр замын гарам дээр осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион явуулж ажилласан. Уг сургалтанд 33 байгууллагын 278 жолооч хамрагдсан.

Төмөр замын удирдах газар дээр зохиогдсон Гармын техникийн хамтарсан зөвөлгөөнд Ахлах зохицуулагч цагдаагийн хошууч Г.Басбиш оролцож төмөр замын гарам дээр гарсан осол, зөрчил, цаашид анхаарч хийх зүйлийн талаар мэдээлэл хийж ажилласан.

ЦЕГ, УБТЗ-ын хувь нийлүүлсэн нийгэмлэг хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Төмөр замын Удирдах газар дээр зохиогдсон “Аюултай бүсийн дэглэм” хамтарсан зөвөлгөөнд ахлах зохицуулагч хошууч Г.Басбиш анхаарах зүйлийн талаар мэдээлэл хийв.

Ази Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зочин төлөөлөгчдийн явах маршрутанд байрлах стандартын шаардлага хангахгүй солих шаардлагатай төмөр замын 6 гармын 34 ширхэг автозамын тэмдгийн судалгааг гаргаж ЗЦГ, ТЗУГ-д хүргүүлсэн.

Төмөр замын гарам дээр осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар Ган зам сонинд сэрэмжлүүлэг хүргүүлж ажилласан.

Улаанбаатар төмөр замын Зорчигч үйлчилгээний төв буудал болон орчмоос хөдөө орон нутагт зохих зөвшөөрөлгүйгээр зорчигч тээвэрлэсэн 10 жолоочийн бичиг баримтыг арга хэмжээ тооцуулахаар Авто тээврийн үндэсний төвд, Нийслэлийн тээврийн газарт 1 жолоочийн бичиг баримтыг тоотоор шилжүүлж, 2 жолоочид дахин энэ төрлийн зөрчил гаргуулахгүй байх талаар сануулж туслах тоо бүртгэлийн санд оруулж шийдвэрлэсэн.

Замын цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран төмөр замын гарам дээр гарч байгаа зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар “Анхаар галт тэрэг” шторк хийлгэж, Улаанбаатар төмөр замын Зорчигч үйлчилгээний төв буудлын хажуугийн Лед дэлгэцээр иргэд жолооч нарт өдөр бүр сурталчилсан.

Иргэд жолооч нарт “АНХААР ЗОГС ГАЛТ ТЭРЭГНЭЭС БОЛГООМЖИЛ” зурагт санамж 2900 ширхэгийг тарааж сурталчилж ажилласан. Зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар 16 байгууллагад албан мэдэгдэл шаардлага өгч 7 мэдэгдэлд хариу авч ажилласан байна.